



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/744

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XVII/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, “Нээлттэй Булган” хөтөлбөр батлах тухай 2023 оны XIII хуралдааны 03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/593 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газрын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах зорилтын хүрээнд Улаанбаатар хотоос шилжин суурьших иргэдийн ажиллах, амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлсэн жишиг сум болсон Хутаг-Өндөр суманд 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгийг Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд “Нээлттэй Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

